



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 130 УГ-СӨГЮУЗ/СГА-ЗСНГ

Г Зөрчил арилгах тухай

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ
ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ГАЗРЫН ДАРГА НАРТ

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад Гадаад харилцааны яамны Дипломат төлөөлөгчийн газруудын төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, улсын үзлэг, тооллоготой холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ОХУ дахь ЭСЯ-ны 2 дугаар байрны А корпусын 3-8 дугаар давхарыг 2007 оноос 10 жилийн хугацаатай түрээслэгч Центр Рейгон Эстейт компани 1 давхар нэмж 9 давхар болгосон, барилгын хийцийг өөрчлөн хана тасалгааг буулгаж, ажлын байр болгон өөрчилсөн, 2 дугаар байрны Б корпуст дээрх компани их засвар хийж, ашиглалтын албан ёсны гэрээ, төлбөргүйгээр ашигладаг, 3 дугаар байр (орон сууц) балансад тусгагдаагүй, өмчлөлийн гэрчилгээгүй,

Болгар Улсын Софи, БНЧУ-ын Прага дахь ЭСЯ-ны барилгын анхны өртөг нь зах зээлийн дундаж үнэтэй харьцуулахад бага үнэлгээтэй, Нью-Йорк дахь БТГ-ын байр 1907 онд ашиглалтад орсон, барилга бүхэлдээ муудсан, Токио дахь ЭСЯ-ны барилга нь 2011 оны 5 баллын хүчтэй газар хөдлөлтөд өртөж их хэмжээний цууралт үүссэн, хүн амьдрахад аюултай гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан,

Вена ЭСЯ-ны барилга 1902 онд ашиглалтад орсон, эмнэлгийн зориулалттай, агааржуулалтгүй, ёслолын үйл ажиллагаа явуулах боломжгүй, ашиглалтын талбай бага, цахилгаан монтаж хуучирч ачааллаа даахаа больсон, бойлерын ашиглалтын хугацаа дууссан тул Вена хотын захиргаанаас хаасан,

Гадаад харилцааны яамны балансаас Нью-Йорк дахь НҮБ-ын БТГ-ын дансанд бүртгэлтэй хөрөнгө 22,6 мянган ам. долларын зөрүүтэй, Парис ЭСЯ-ны тээврийн хэрэгслэл 9.3 мянган ам. доллар, Вашингтон ЭСЯ-ны тавилга эд хогшил 16.1 мянган ам. доллар, Софи ЭСЯ-ны машин тоног төхөөрөмж 6.3 мянган ам. доллар, тавилга эд хогшил 19.6 мянган ам. доллараар тус тус зөрүүтэй илэрхийгдсэн зэрэг нийт 94,105.960.00 төгрөгийн зөрчлүүд илэрсэн байна.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн Дээрхи дурдсан барилгуудын талаар зохих журам зааврын дагуу холбогдох арга хэмжээг авах, үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд явуулж, үр дунг гаргаж, хөрөнгийн үлдэглийг баталгаажуулж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг Гадаад харилцааны яамны СХОХ-ийн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, ахлах нягтлан бодогч Ч.Ганбат нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

